



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



Төсөл, арга хэмжээний баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж гүйцэтгэлээр нь санхүүжилтийг олгосон ч гэрээнд заасан хугацаандаа хэрэгжүүлээгүй 3 төсөл, арга хэмжээ байна.

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	Агуулга	2
Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь	Товчилсон үгийн тайлал	3
Аудитын менежер М.Бат-Амгалан	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
Ахлах аудитор Ч.Мөнхтогтох	Бүлэг А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж гүйцэтгэлээр нь санхүүжилтийг олгосон байна.	5
Аудитор Т.Золоо А.Нанжидмаа	<i>А.1. Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний зураг төсөл, ажлын даалгавар, техникийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулсан байна.</i>	5
	<i>А.2. Төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-аар баталсан ч аймгийн Засаг дарга 1 төсөл, арга хэмжээнд өөрчлөлт оруулсан байна.</i>	8
2024 оны 6 дугаар сар	<i>А.3. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан ч 3 сум үнэлгээний хороонд төрийн бус байгууллагын төлөөлөл оруулаагүй байна.</i>	10
	<i>А.4. Хяргас нуурын эргийн тохижилт, засвар шинэчлэлийн 64.9 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг үүрэг даалгавартайгаар хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон байна.</i>	14
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317 дугаарын утсаар харилцана уу.	Бүлэг Б. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэсэн боловч гэрээний хугацаанд хийгдэж дуусаагүй 3 төсөл, арга хэмжээ байна.	16
Хаяг: Увс аймаг дахь Төрийн аудитын газар Улаангом сум 3 дугаар баг, аймгийн Засаг даргын тамгын газрын байр	<i>Б.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэсэн боловч гэрээний хугацаанд хийгдэж дуусаагүй 3 төсөл, арга хэмжээ байна.</i>	16
	<i>Б.2. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.</i>	19

	Б.3. Хэрэгжүүлж дууссан Хөх нуурын эргийн тохижилт 9.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг данс бүртгэлд тусгаагүй байна.	20
	Бүлэг В. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 1 төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаж эхлээгүй, 1 төсөл, арга хэмжээ чанар муутай хийгдсэн байна.	21
	В.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн хог шатаах зуухыг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаж эхлээгүй байна.	21
	В.2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Улаангом сумын 1-р Цэцэрлэгийн урлаг заалны дээврийн засвар чанар муутай хийгдсэн байна.	23
		29
	Дүгнэлт	30
	Холбогдох байгууллагын санал	
	Аудитын газраас өгөх тайлбар	
	Зөвлөмж	

Товчилсон үгийн тайлал:

УВА	Увс аймаг
ШТА	Шууд тайлагнах аудит
ГА	Гүйцэтгэлийн аудит
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их хурал
ШТС	Шатахуун түгээх станц
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын төлөвлөгөө батлах тухай” 8 дугаар тогтоол, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/152 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийлээ.

Аудитын зорилт

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулж дүнг Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх;
- Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх.

Хамарсан хүрээ

Аудитыг аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 14/01 дүгээр тогтоолоор баталсан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 34, авто замын сангийн хөрөнгө оруулалтын 4, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 1, нийт 39 төсөл, арга хэмжээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага, аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн хийлээ.

Аудитад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд санхүүжүүлэхээр баталсан 39 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллага, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулсан.

Аудитын хүрээнд аймгийн төвийн болон хөдөөгийн 4 суманд очиж ажилласан бөгөөд бусад төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг албан мэйлээр холбогдох баримт материал, фото зургийн авч баримтжууллаа.

Арга зүй

Аудитад гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт болон “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа авах зэрэг арга зүйг ашиглав.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Гүйцэтгэлийн аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан аудитын стандартыг хангуулан, үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ч.Мөнхтогтох, аудитор А.Нанжидмаа, Т.Золоо нар хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий зүйл

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2023 оны төсвийн жилд хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг анх аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 11/03 дугаар тогтоолоор баталж, 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 14/01 дүгээр тогтоолоор тодотгол хийсэн байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,886.0 сая төгрөгийн 34 төсөл, арга хэмжээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 22.7 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ, авто замын сангийн хөрөнгөөр 745.6 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ, нийт 2,654.3 сая төгрөгийн 39 төсөл, арга хэмжээг тодотгон баталсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдэд 2023 онд 2,654.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 86.5 хувь буюу 2,295.6 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

БҮЛЭГ:А. Хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж гүйцэтгэлээр нь санхүүжилтийг олгосон байна.

А.1. Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний зураг төсөл, ажлын даалгавар, техникийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан 39 төсөл, арга хэмжээ нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зарчим, Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, салбарын бодлогод дараах байдлаар нийцэж байна.Үүнд:

Хүснэгт №01

Д/д	Бодлогын баримт бичиг	Бүлгийн агуулга
1	Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”, Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 5 бүлэг болгон баталсанд нийцэж байна.	Хүний хөгжлийн бодлого
		Эдийн засгийн бодлого
		Засаглалын бодлого
		Ногоон хөгжлийн бодлого
		Бүс, сум, орон нутгийн хөгжлийн бодлого
2	Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 8 бүлэг болгон баталсанд нийцэж байна.	Үндэсний нэгдмэл үнэт зүйл
		Хүний хөгжил
		Амьдралын чанар ба дундаж давхарга
		Эдийн засаг
		Засаглал
		Ногоон хөгжил
		Амар тайван, аюулгүй нийгэм
		Бүс, сум, орон нутгийн хөгжил

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 34 төсөл, арга хэмжээ, замын сангийн хөрөнгө оруулалтаар 4 төсөл, арга хэмжээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх 1 төсөл, арга хэмжээ, нийт 39 төсөл, арга хэмжээнээс өмнөх оноос шилжсэн 3, он дамжин хэрэгжиж байгаа 3, тайлант онд хэрэгжиж дууссан 31, хэрэгжүүлээгүй 2 төсөл, арга хэмжээ байна. Тайлант онд хэрэгжүүлэх 39 төсөл, арга хэмжээнээс зураг төсөв, магадлалын дүгнэлттэй 3 төсөл, арга хэмжээ, ажлын даалгавар техникийн тодорхойлолттой 36 төсөл, арга хэмжээ байна.

Зураг төсөв, магадлалын дүгнэлттэй төсөл, арга хэмжээний мэдээлэл

Хүснэгт №01

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг (мян.төг)	Магадлалын дүгнэлт
1	Гашууны голын гүүрнээс Шунхлай ШТС-ын аюулгүйн тойрог хүртэлх замын гэрэлтүүлгийн ажил	138,176.0	2022.04.07 65/2022
2	Хатуу хучилттай авто зам, тохижилтын ажил /5-р баг/	420,000.0	2023.05.08 96/2023
3	Ерөнхий боловсролын 4-р сургуулийн чиглэлийн шороон замын тохижилт	225,581.0	2022.12.28 503/2022

Эх сурвалж: 2023 оны ОНТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Ажлын даалгавар, техникийн тодорхойлолттой төсөл арга хэмжээний мэдээлэл

Хүснэгт №02

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Хугацаа		Төсөвт өртөг (мян.төг)	ажлын даалгавар, техникийн тодорхойлолттой эсэх /тийм, үгүй/
			Эхлэх	Дуусах		
1	1 дүгээр цэцэрлэгийн урлаг заалны дээврийн засвар, шинэчлэл	Их засвар	2023	2023	42,605.0	тийм
2	Хяргас нуурын эргийн тохижилт, засвар шинэчлэл багц1	Барилга байгууламж	2023	2023	64,888.9	тийм
	Хяргас нуурын эргийн тохижилт, засвар шинэчлэл багц2	Барилга байгууламж	2023	2023	9,985.0	тийм
3	Увс аймаг дахь Цагдаагийн газарт ашиглагдаж байгаа камерын хяналтын төвийн шинэчлэл, өргөтгөлийн ажил	Тоног төхөөрөмж	2023	2023	69,900.0	тийм
4	Зэвсэгт хүчний 328-р тусгай салбарын тоног төхөөрөмж	Тоног төхөөрөмж	2023	2023	15,000.0	тийм
5	Сумын төвийн ногоон байгууламж, засвар, тохижилт /Зүүнговь/	Их засвар	2023	2023	90,000.0	тийм
6	Архивын тасагт шаардлагатай тоног төхөөрөмж	Тоног төхөөрөмж	2023	2023	29,143.0	тийм
7	Аймгийн Засаг Даргын Тамгын газрын тохижилт	Их засвар	2023	2023	25,000.0	тийм
8	Сургуулийн дотуур байр, Соёлын төвд хэрэгцээтэй тоног төхөөрөмж /Бөхмөрөн/	Тоног төхөөрөмж	2023	2023	72,380.0	тийм
9	Жуулчдад мэдээлэл өгөх цэг, отоглох талбай байгуулах	Барилга байгууламж	2023	2023	103,756.0	тийм
10	Газар тариалангийн талбайн хамгаалалтын тор татах	Барилга байгууламж	2023	2023	128,485.0	тийм
11	Сумын төвийн тохижилт, шинэчлэлийн ажил /Цагаанхайрхан/	Их засвар	2023	2023	100,000.0	тийм
12	Биеийн тамир спортын газрын гадна талбайн тохижилт	Их засвар	2023	2023	196,035.0	тийм
13	Ариутгал, халдваргүйтэл, эмчилгээний техник тоног төхөөрөмж /Түргэн/	Тоног төхөөрөмж	2023	2023	80,000.0	тийм
14	Хуучин ЗДТГ-ын байрыг буулгах, сумын төвийн тохижилт	Их засвар	2023	2023	50,000.0	тийм
15	Цэцэрлэгийн засвар, шинэчлэлийн ажил	Их засвар	2023	2023	80,000.0	тийм
16	Сумын төвийн шороон замын засвар шинэчлэл /Өндөрхангай/	Их засвар	2023	2023	30,000.0	тийм
17	2-р багийн зам засварын ажил	Их засвар	2023	2023	49,986.0	тийм
18	6-р баг тээврийн хорооны чиглэлд гэрэлтүүлэг	Барилга байгууламж	2023	2023	77,501.0	тийм
19	8-р багийн Овоон булангийн зам засвар	Их засвар	2023	2023	49,922.0	тийм

20	9-р багийн төвийн тохижилт	Их засвар	2023	2023	48,959.0	тийм
21	Хилийн цэргийн 0245-р ангийн Боршоо боомт дахь байр	Их засвар	2023	2023	40,000.0	тийм
22	0311-р анги завь худалдан авах	Их засвар	2023	2023	30,000.0	тийм
23	Иргэдийн усан хангамжийг сайжруулах /Зүүнхангай/	Тоног төхөөрөмж	2023	2023	50,000.0	тийм
24	Сумын Эрүүл мэндийн төвд эхо, тоног төхөөрөмж /Өлгий/	Тоног төхөөрөмж	2023	2023	45,000.0	тийм
25	Сумын төвийн тохижилт /Тэс/	Их засвар	2023	2023	48,936.0	тийм
26	Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх явуулын лабораторийн автобус авах /МЭГ/	Тоног төхөөрөмж	2023	2023	20,000.0	тийм
27	Хяргас нуурын "Усны сургалт, хяналт дадлагын төвд" ариун цэврийн байгууламж барихад дэмжлэг	Барилга байгууламж	2023	2023	20,000.0	тийм
28	Хэвлэл мэдээллийн тоног төхөөрөмж шинэчлэл /АЗДТГ/	Тоног төхөөрөмж	2023	2023	6,654.9	тийм
29	Сумын 4,5,8,9-р багийн хүний эмчийг унаажуулах /ЭМТ/	Тоног төхөөрөмж	2023	2023	13,500.0	тийм
30	Цэцэрлэгийн засвар, тохижилт	Их засвар	2023	2023	11,500.0	тийм
31	Галданбошигт хүндэтгэлийн өргөөний засварын ажлын санхүүжилтийн үлдэгдэл	Их засвар	2022	2023	3,964.3	тийм
32	"Наадмын талбайн ногоон байгууламж" ажлын санхүүжилтийн үлдэгдэл	Их засвар	2022	2023	3,212.8	тийм
33	"Орлогын голд модон гүүрний засвар шинэчлэл" ажлын санхүүжилтийн үлдэгдэл	Барилга байгууламж	2022	2023	41,512.0	тийм
34	Нуурын эргийн менежмент үйлчилгээг зохион байгуулах	Тоног төхөөрөмж	2023	2023	22,750.0	тийм
35	Автозамын шороо, тоос бууруулах бодис худалдан авах	Тоног төхөөрөмж	2023	2023	50,000.0	тийм
36	Улаангом сум доторх авто замын явган хүний гарцад дуут дохио, замын тэмдэг, тэмдэглэгээ, засвар арчлалтын ажил	Их засвар	2023	2023	50,000.0	тийм

Эх сурвалж: 2023 оны ОНТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

А.2. Төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-аар баталсан ч аймгийн Засаг дарга 1 төсөл, арга хэмжээнд өөрчлөлт оруулсан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 5.1.1-д заасан төсвийн тогтвортой байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.2.3 дахь заалтад “Урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх”, 6.2.6 дахь заалтад “Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага нь Засгийн газар, Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд өөрчлөлт оруулахаар бол доор дурдсан зохицуулалт хийнэ”, 6.2.6.а-д “Тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний

зарлагыг нэмэгдүүлэхээр бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулж, нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх” гэж заажээ.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 11/03 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны төсөв батлахдаа орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2,097.5 сая төгрөгийн 28 төсөл, арга хэмжээ, замын сангийн хөрөнгө оруулалтаар 700.0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ, байгаль орчныг нөхөн сэргээх 22.7 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ, нийт 2,820.2 сая төгрөгийн 33 төсөл, арга хэмжээ төлөвлөн баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 14/01 дүгээр тогтоолоор аймгийн 2023 оны төсөвт тодотгол хийхдээ орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,886.0 сая төгрөгийн 34 төсөл, арга хэмжээ, замын сангийн хөрөнгө оруулалтаар 745.6 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ, байгаль орчныг нөхөн сэргээхэд 22.7 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ, нийт 2,654.3 сая төгрөгийн 39 төсөл, арга хэмжээг баталсан байна. Энэ нь анх баталсан төсөл, арга хэмжээнээс 276.4 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг хасаж, 120.3 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээг нэмж баталсан байна. Үүнд:

Хасагдсан төсөл, арга, хэмжээний хувьд:

- Улаангом сумын 9-р цэцэрлэгийн завсар, шинэчлэл 226.4 сая,
- Сагил сумын Мал төхөөрөх цехийн тоног төхөөрөмж 50.0 сая,

Нэмэгдэж батлагдсан төсөл, арга хэмжээний хувьд:

- Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, явуулын лабораторийн автобус авах 20.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ нь малын гоц халдварт өвчлөл ихэссэнтэй холбоотойгоор,
- Хяргас нуурын “Усны сургалт, хяналт дадлагын төвд” ариун цэврийн байгууламж барихад дэмжлэг 20.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг улсын тусгай хамгаалалттай газрын хөрс, усны бохирдол ихсэж байгаатай холбоотой ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлэх шаардлагаар,
- Аймгийн Засаг даргын тамгын газрын хэвлэл мэдээллийн тоног төхөөрөмжийн шинэчлэлийн 6.6 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ нь тоног төхөөрөмж хуучирч ашиглах боломжгүй болсонтой холбоотойгоор,
- Тэс сумын 4, 5, 8, 9-р багийн хүний эмчийг унаажуулах 13.5 сая, Цэцэрлэгийн засвар тохижилт 11.5 сая, нийт 25.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг ЭМТ болон Цэцэрлэгийн тэгш ой тохиож байгаатай холбогдуулан,

- Галдан бошигт хүндэтгэлийн өргөөний засвар 3.9 сая, Улаангом сумын наадмын талбайн ногоон байгууламж 3.2 сая, Өмнөговь сумын Орлогын голд модон гүүрний засвар шинэчлэлийн 41.5 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний өмнөх оны дутуу санхүүжилт

Аймгийн ИТХ-аар баталсан Хяргас нуурын эргийн тохижилт, засвар шинэчлэлийн 74.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/225 дугаар захирамжаар Хяргас нуурын эргийн тохижилт, засвар шинэчлэл 65.0 сая, Улаангом сумын 2-р багийн Хөх нуурын эргийн тохижилт 10.0 сая төгрөгийн 2 багц төсөл, арга хэмжээ болгон задалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 64.1.2 дахь заалтад “Тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх”, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 35.1.9 дэх хэсэгт “Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах” гэж заасныг тус тус зөрчиж аймгийн ИТХ-аар баталсан төсөл, арга хэмжээний нэр, байршил, зориулалтыг өөрчилсөн байна.

Цаашид аймгийн ИТХ-аар баталсан төсөл, арга хэмжээнд өөрчлөлт оруулахгүй байхыг зөвлөмж болгов.

А.3. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан ч 3 сум үнэлгээний хороонд төрийн бус байгууллагын төлөөлөл оруулаагүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт хэрэгжүүлэх 39 төсөл, арга хэмжээнээс эрх шилжүүлээгүй 18 төсөл, арга хэмжээ, өмнөх онд эрх шилжүүлсэн 2 төсөл, арга хэмжээ, 19 төсөл, арга хэмжээний эрхийг тайлант онд харьяалах төсвийн захирагч нарт хэрэгжих боломжтой хугацаанд шилжүүлсэн байна. Үүнд:

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/04 дүгээр захирамжаар 7 төсөл, арга хэмжээг:

- Зэвсэгт хүчний 328-р тусгай салбарын тоног төхөөрөмж
- Зүүнговь сумын төвийн ногоон байгууламж, засвар, тохижилт
- Аймгийн Засаг даргын тамгын газрын тохижилт
- Давст сумын ЗДТГ-ын хуучин байрыг буулгах, сумын төвийн тохижилт
- Наранбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн засвар, шинэчлэлийн ажил
- Өндөрхангай сумын төвийн шороон замын засвар шинэчлэл
- Зүүнхангай сумын иргэдийн усан хангамжийг сайжруулах

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/29 дүгээр захирамжаар 3 төсөл, арга хэмжээг:

- Архивын тасагт шаардлагатай тоног төхөөрөмж
- Хилийн цэргийн 0245-р ангийн Боршоо боомт дахь байр
- Тэс сумын төвийн тохижилт

Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/130 дугаар захирамжаар 2 төсөл, арга хэмжээг:

- Улаангом сумын 2-р багийн зам засварын ажил
- Улаангом сумын 8-р багийн Овоон булангийн зам засвар

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/190 дүгээр захирамжаар байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх 1 төсөл, арга хэмжээ,

- Нуурын эргийн менежмент үйлчилгээг зохион байгуулах

2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/285 дугаар захирамжаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 1 төсөл, арга хэмжээ,

- Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх явуулын лабораторийн автобус авах

2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/305 дугаар захирамжаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 1 төсөл, арга хэмжээ,

- Хяргас нуурын "Усны сургалт, хяналт дадлагын төвд" ариун цэврийн байгууламж барихад дэмжлэг

2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/319 дүгээр захирамжаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 1 төсөл, арга хэмжээг

- 0311-р анги завь худалдан авах

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн А/462 дугаар захирамжаар 3 төсөл, арга хэмжээг:

- Тэс сумын 4, 5, 8, 9-р багийн эмчийг унаажуулах
- Тэс сумын Хүүхдийн цэцэрлэгийн засвар, тохижилт
- Аймгийн ЗДТГ-т Хэвлэл мэдээллийн тоног төхөөрөмж шинэчлэл

Аймгийн замын сангийн 416.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Хатуу хучилттай авто зам, тохижилтын /Улаангом 5-р баг/”-ын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах УВАОНӨГ/202312039 дугаартай тендерийг 2023 оны 06 дугаар сарын 30, 2023 оны 8 дугаар сарын 10-ны өдөр тус тус зарласан ба тухайн тендэрт оролцогчид нь тендерийн баримт бичигт тусгасан шаардлага хангахгүй байсан тул үнэлгээний хорооноос тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасан нөхцөл үүссэний дагуу шууд гэрээ байгуулах зөвлөмжийг 2023 оны 8 дугаар сарын 28-ны өдөр захиалагчид хүргүүлсний дагуу аймгийн Засаг дарга 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр “Цэнгийн зам” ХХК-

тай 416.8 сая төгрөгийн “Хатуу хучилттай авто зам, тохижилт /Улаангом 5-р баг/-ын ажилд УБАОНӨГ/202312039 дугаар шууд гэрээг байгуулж гүйцэтгүүлсэн байна.

Ингэхдээ тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана”, 34.3 дахь заалтад “Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаагүй байх бөгөөд тухайн тендерийг 2 удаа зарлахад оролцож тендерийн баримт бичигт тусгасан шаардлага хангахгүй гэсэн үндэслэлээр шалгараагүй “Цэнгийн зам” ХХК-тай шууд гэрээ байгуулсан байна.

Дээрх асуудлыг ТЕЗ-ын нэгтгэсэн тайланд нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, өөртөө болон бусдад давуу байдал бий болгосон байж болзошгүй гэж хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахаар Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 198 дугаар бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.

Орон нутгийн өмчийн газар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 14 төсөл, арга хэмжээнд шууд гэрээ байгуулж, 25 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааг явуулахдаа 10 төсөл, арга хэмжээнд харьцуулалтын арга, 15 төсөл, арга хэмжээнд нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргыг ашигласан байна.

Хүснэгт
№03

Д/Д	Байгууллагын нэр	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөвт өртөг (Мян.төг)	Эрх шилжүүлсэн эсэх	Гэрээний дүн (мян.төг)	Санхүүжүүлсэн дүн	ХАА-нд мөрдсөн журам
1	ОНӨГ ХХА	Газар тариалангийн талбайн хамгаалалтын тор татах /Баруунтуруун сум/	143,621.6	Үгүй	128,485.0	128,485.0	НТШ
2	ОНӨГ ХХА	Жуулчдад мэдээлэл өгөх цэг, отоглох талбай байгуулах /Тэс сум/	105,000.0	Үгүй	103,755.8	103,755.8	НТШ
3	ОНӨГ ХХА	Хяргас нуурын эргийн тохижилт, засвар шинэчлэл Багц 1, Багц -2	75,000.0	Үгүй	74,871.9	74,871.9	НТШ
4	ОНӨГ ХХА	6-р баг тээврийн хорооны чиглэлд гэрэлтүүлэг /Улаангом сум/	80,000.0	Үгүй	77,500.0	77,500.0	НТШ
5	ОНӨГ ХХА	9-р багийн төвийн тохижилт /Улаангом сум/ худаг	50,000.0	Үгүй	48,958.9	48,959.0	НТШ

6	ОНӨГ ХХА	Гашууны голын гүүрнээс Шунхлай ШТС-ын аюулгүйн тойрог хүртэлх замын гэрэлтүүлгийн ажил	151,000.0	Үгүй	138,175.7	138,175.7	НТШ
7	ОНӨГ ХХА	Ариутгал, халдваргүйтгэл, эмчилгээний техник тоног төхөөрөмж /Түргэн сум/	30,000.0 50,000.0	Үгүй	80,000.0	80,000.0	НТШ
8	ОНӨГ ХХА	Биеийн тамир спортын газрын гадна талбайн тохижилт	200,000.0	Үгүй	196,034.2	196,034.2	НТШ
9	ОНӨГ ХХА	Сумын төвийн тохижилт, шинэчлэлийн ажил /Цагаанхайрхан сум/	100,000.0	Үгүй	100,000.00	100,000.0	НТШ
10	ОНӨГ ХХА	Өлгий сумын Эрүүл мэндийн төвд эхо, тоног төхөөрөмж	45,000.0	Үгүй	44,670.0	44,670.0	НТШ
11	ОНӨГ ХХА	Сургуулийн дотуур байр, Соёлын төвд хэрэгцээтэй тоног төхөөрөмж /Бөхмөрөн сум/	72,380.0	Үгүй	72,380.0	72,380.0	НТШ
12	ОНӨГ ХХА	1 дүгээр цэцэрлэгийн урлаг заалны дээврийн засвар, шинэчлэл	45,000.0	Үгүй	42,604.9	42,604.9	НТШ
13	ОНӨГ ХХА	Увс аймаг дахь Цагдаагийн газарт ашиглагдаж байгаа камерын хяналтын төвийн шинэчлэл, өргөтгөлийн ажил	71,500.0	Үгүй	71,500.0	71,500.0	НТШ
14	Тэс	Сумын төвийн тохижилт/ Тэс сум/	48,936.0	тийм	48,588.1	48,588.1	ХА
15	Наранбулаг	Цэцэрлэгийн засвар шинэчлэл	80,000.0	тийм	80,000.0	80,000.0	НТШ
16	ОНӨГ ХХА	Хатуу хүчилттай авто зам, тохижилтын ажил	420,000.0	Үгүй	416,771.2	174,699.9	НТШ
17	Улаангом	2-р багийн зам засварын ажил	49,986.0	тийм	49,895.4	49,895.4	ХА
18	Улаангом	8-р багийн Овооны булангийн зам засварын ажил	49,922.0	тийм	49,921.6	49,921.6	ХА
19	Аймгийн ЗДТГ	Архивын тасагт шаардлагатай тоног төхөөрөмж	29,143.0	тийм	29,143.0	29,143.0	ХА
20	Аймгийн ЗДТГ	Аймгийн ЗДТГ-ын тохижилт	25,000.0	тийм	23,915.0	23,915.0	ХА
21	Давст	Хуучин ЗДТГ-ын байрыг буулгах, умын төвийн тохижилт	50,000.0	тийм	49,998.9	25,599.5	ХА
22	Өндөрхангай	Сумын төвийн шороон замын засвар шинэчлэлийн ажил	30,000.0	тийм	29,855.0	29,855.0	ХА
23	Зүүнхангай	Иргэдийн усан хангамжийн сайжруулах	50,000.0	тийм	50,000.0	50,000.0	ХА
24	Зүүнговь	Сумын төвийн ногоон байгууламж, засвар, тохижилт	90,000.0	тийм	85,887.0	85,887.0	ХА
25	БОАЖГазар	Нуурын эргийн менежмент үйлчилгээг зохион байгуулах /хог хаягдал, эко жорлон/	22,750.0	тийм	22,750.0	22,750.0	ХА
			1,787,345.6		1,774,191.19	1,482,224.5	

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасны дагуу аймаг, сумдын Засаг даргын захирамжаар төсөл, арга хэмжээ бүрд үнэлгээний хороог байгуулсан байна.

Эрх шилжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний үнэлгээний хороог байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4. дэх хэсэгт “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас

томилсон иргэн, Засаг даргын тамгын газрын ажилтныг оролцуулна” гэж заасныг Тэс, Өндөрхангай, Зүүнхангай сум зөрчсөн байна.

Цаашид үнэлгээний хороо байгуулахдаа тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, эсхүл төрийн бус байгууллагын төлөөлөл томилж байхыг зөвлөмж болголоо.

А.4. Хяргас нуурын эргийн тохижилт, засвар шинэчлэлийн 64.9 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг үүрэг даалгавартайгаар хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.6 дахь заалтад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэж заажээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 39 төсөл, арга хэмжээнээс тайлант оны 30 төсөл, арга хэмжээ, өмнөх оноос шилжиж ирсэн 3 төсөл, арга хэмжээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх 1 төсөл, арга хэмжээ, авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн 1 төсөл, арга хэмжээ, нийт 35 төсөл, арга хэмжээг хүлээн авч санхүүжилтийг 100 хувь олгосон байна.

Дээрх төсөл, арга хэмжээнээс Хяргас нуурын эргийн тохижилт, засвар шинэчлэлийн 64.9 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний Тендер шалгаруулалтыг 3 удаа зарлаж “Энх дормон” ХХК-тай 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдөр хийж дуусгах гэрээ байгуулсан байна. Уг төсөл, арга хэмжээний ажлын зураг, тоо хэмжээнд өөрчлөлт оруулж 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хүлээлгэн өгөхөөр сунгасан ч тухайн төсөл арга хэмжээг хийж дуусгаагүй байхад санхүүжилтийг 100% олгож улсын комисс үүрэг даалгавартайгаар ашиглалтад хүлээн авсан байна.

Дээрх төсөл, арга хэмжээг бүрэн хийлгэж хүлээн авахыг зөвлөмж болгов.

2023 оны Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний гэрээний дүн, олгосон санхүүжилт

Хүснэгт №04

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Гэрээний дүн мян.төг	Олгосон санхүүжилт
		Эхлэх	Дуусах		
1	Гашууны голын гүүрнээс Шунхлай ШТС-ын аюулгүйн тойрог хүртэлх замын гэрэлтүүлгийн ажил	2023	2023	138,175.7	135,868.8
2	1 дүгээр цэцэрлэгийн урлаг заалны дээврийн засвар, шинэчлэл	2023	2023	42,604.9	42,604.9
3	Хяргас нуурын эргийн тохижилт, засвар шинэчлэл багц	2023	2023	64,888.9	64,888.9
	Хяргас нуурын эргийн тохижилт, засвар шинэчлэл багц2	2023	2023	9,983.1	9,983.1
4	Увс аймаг дахь Цагдаагийн газарт ашиглагдаж байгаа камерын хяналтын төвийн шинэчлэл, өргөтгөлийн ажил	2023	2023	69,900.0	69,900.0

5	Зэвсэгт хүчний 328-р тусгай салбарын тоног төхөөрөмж	2023	2023	15,000.0	15,000.0
6	Сумын төвийн ногоон байгууламж, засвар, тохижилт	2023	2023	85,887.0	85,887.0
7	Архивын тасагт шаардлагатай тоног төхөөрөмж	2023	2023	29,143.0	29,143.0
8	Аймгийн Засаг Даргын Тамгын газрын тохижилт	2023	2023	23,915.0	23,915.0
9	Сургуулийн дотуур байр, Соёлын төвд хэрэгцээтэй тоног төхөөрөмж	2023	2023	72,380.0	72,380.0
10	Жуулчдад мэдээлэл өгөх цэг, отоглох талбай байгуулах	2023	2023	103,755.8	103,755.8
11	Газар тариалангийн талбайн хамгаалалтын тор татах	2023	2023	128,485.0	128,485.0
12	Сумын төвийн тохижилт, шинэчлэлийн ажил	2023	2023	100,000.0	100,000.0
13	Биеийн тамир спортын газрын гадна талбайн тохижилт	2023	2023	196,034.2	196,034.2
14	Ариутгал, халдваргүйтлэл, эмчилгээний техник тоног төхөөрөмж	2023	2023	80,000.0	80,000.0
15	Цэцэрлэгийн засвар, шинэчлэлийн ажил	2023	2023	80,000.0	80,000.0
16	Сумын төвийн шороон замын засвар шинэчлэл	2023	2023	29,855.0	29,855.0
17	2-р багийн зам засварын ажил	2023	2023	49,895.4	49,895.4
18	6-р баг тээврийн хорооны чиглэлд гэрэлтүүлэг	2023	2023	77,500.0	77,500.0
19	8-р багийн Овоон булангийн зам засвар	2023	2023	49,921.6	49,921.6
20	9-р багийн төвийн тохижилт	2023	2023	48,958.9	48,958.9
21	Хилийн цэргийн 0245-р ангийн Боршоо боомт дахь байр	2023	2023	40,000.0	40,000.0
22	0311-р анги завь худалдан авах	2023	2023	30,000.0	30,000.0
23	Иргэдийн усан хангамжийг сайжруулах	2023	2023	50,000.0	50,000.0
24	Сумын Эрүүл мэндийн төвд эхо, тоног төхөөрөмж	2023	2023	45,000.0	44,670.0
25	Сумын төвийн тохижилт	2023	2023	48,588.2	48,588.2
26	Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх явуулын лабораторийн автобус авах /МЭГ/	2023	2023	20,000.0	20,000.0
27	Хяргас нуурын "Усны сургалт, хяналт дадлагын төвд" ариун цэврийн байгууламж барихад дэмжлэг	2023	2023	20,000.0	20,000.0
28	Хэвлэл мэдээллийн тоног төхөөрөмж шинэчлэл /АЗДТГ/	2023	2023	6,654.9	6,654.9
29	Сумын 4,5,8,9-р багийн хүний эмчийг унаажуулах /ЭМТ/	2023	2023	13,500.0	13,500.0
30	Цэцэрлэгийн засвар, тохижилт	2023	2023	11,500.0	11,500.0
31	Галданбошигт хүндэтгэлийн өргөөний засварын ажлын санхүүжилтийн үлдэгдэл	2022	2023	3,964.3	3,964.3
32	"Наадмын талбайн ногоон байгууламж" ажлын санхүүжилтийн үлдэгдэл	2022	2023	3,212.8	2,351.9
33	"Орлогын голд модон гүүрний засвар шинэчлэл" ажлын санхүүжилтийн үлдэгдэл	2022	2023	41,512.0	41,512.0
34	Нуурын эргийн менежмент үйлчилгээг зохион байгуулах /хог хаягдал, эко жорлон/	2023	2023	22,750.0	22,750.0
35	Ерөнхий боловсролын 4-р сургуулийн чиглэлийн шороон замын тохижилт	2023	2023	225,581.0	225,581.0

Эх сурвалж: 2023 оны ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Хугацаандаа хэрэгжиж дуусаагүй орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг дутуу олгосон байна.Үүнд:

Хүснэгт№05

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мян.төг/	Гэрээний эхлэх, дуусах огноо	2023 онд олгосон санхүүжилт /мян.төг/	Хэрэгжиж дууссан эсэх /тийм, үгүй, хугацаа болоогүй/	Тайлбар
1	Хатуу хучилттай авто зам, тохижилтын ажил /5-р баг/	416,771.2	2023.09.08-2023.11.10	194,431.3	үгүй	Хугацаандаа ажлаа хийж гүйцэтгээгүй гэрээ сунгасан
2	Давст сумын ЗДТГ-ын хуучин байрыг буулгах, сумын төвийн тохижилт	50,000.0	2023.10.05-2023.11.10	25,599.5	үгүй	Хугацаандаа ажлаа хийж гүйцэтгээгүй гэрээ сунгасан

Эх сурвалж: 2023 оны ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Хэрэгжээгүй 2 төсөл, арга хэмжээнд санхүүжилт олгоогүй байна. Үүнд:

Хүснэгт№06

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Гэрээний эхлэх, дуусах огноо	2023 онд олгосон санхүүжилт /сая.төг/	Хэрэгжиж дууссан эсэх /тийм, үгүй, хугацаа болоогүй/	Тайлбар
1	Улаангом сум доторх авто замын явган хүний гарцад дуут дохио, замын тэмдэг, тэмдэглэгээ, засвар арчлалтын ажил	50,000.0	-	-	-	Тендер сонгон шалгаруулалтад материал ирээгүй
2	Автозамын шороо, тоос бууруулах бодис худалдан авах	50,000.0	-	-	-	Тендер сонгон шалгаруулалт явуулж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан ч ажил нь хийгдээгүй.

Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжих Улаангом сум доторх авто замын явган хүний гарц дуут дохио, замын тэмдэг, тэмдэглэгээ, засвар арчлалтын 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд тендерийн бичиг баримтын шаардлага хангасан оролцогч орж ирээгүй тул хэрэгжээгүй, автозамын шороо, тоос бууруулах бодис худалдан авах 1 төсөл, арга хэмжээг тендер сонгон шалгаруулалт явуулж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан хэдий ч ажлаа хийж гүйцэтгээгүй тул санхүүжилтийг олгоогүй байна.

БҮЛЭГ:Б. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч хэрэгжээгүй 2, гэрээнд заасан хугацаандаа хэрэгжүүлээгүй 3 төсөл, арга хэмжээ байна.

Б.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэсэн боловч гэрээний хугацаанд хийгдэж дуусаагүй 3 төсөл, арга хэмжээ байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 39 төсөл, арга хэмжээнээс дутуу хэрэгжүүлсэн 3, хэрэгжээгүй 2 төсөл, арга хэмжээнээс бусад 34 төсөл, арга хэмжээг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр хүлээн авч байна.

Дараах 3 төсөл, арга хэмжээний гэрээний хугацааг сунгасан байна.

- Давст сумын ЗДТГ-ын хуучин байрыг буулгах, сумын төвийн тохижилтын 49.9 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд оролцогч “Хос залаат” ХХК-аас Сангийн яаманд гомдол гаргаж хянан шийдвэрлэгдэх хүртэл хугацаа алдсан байна.
- Хяргас нуурын эргийн тохижилт, засвар шинэчлэлийн 64.9 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний ажлын зураг болон, тоо хэмжээнд өөрчлөлт орсон байна.
- Хатуу хучилттай авто зам, тохижилтын 416.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд бичиг баримтын шаардлага хангасан оролцогч орж ирээгүйгээс хугацаа алдсан байна.

Гэрээний хугацаанд хийж дуусгаагүй, хугацаа сунгасан төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч компаниар гүйцэтгүүлэхийг зөвлөмж болгов.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж батлагдсан ч хэрэгжээгүй 2 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- Улаангом сум доторх авто замын явган хүний гарцад дуут дохио, замын тэмдэг, тэмдэглэгээ, засвар арчлалтын ажил
- Автозамын шороо, тоос бууруулах бодис худалдан авах

Өмнөх оноос шилжиж ирсэн 3 төсөл, арга хэмжээний мэдээллийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт№07

№	Төсөл, арга хэмжээний нэр	2023 онд олгосон санхүүжилт /мян.төг/	Хүлээн авсан актын огноо
1	Галданбошигт хүндэтгэлийн өргөөний засварын ажлын санхүүжилтийн үлдэгдэл	3,964.3	2023.12.13
2	“Наадмын талбайн ногоон байгууламж” ажлын санхүүжилтийн үлдэгдэл	3,212.8	2023.07.19
3	“Орлогын голд модон гүүрний засвар шинэчлэл” ажлын санхүүжилтийн үлдэгдэл	41,512.0	2023.11.06

Эх сурвалж: 2023 оны ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Б.2. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт “Аймаг, нийслэлийн Засаг дарга барилгын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 35.1.1 дэх заалтад “Нутаг дэвсгэртээ барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих”, 35.1.4 дэх заалтад “Тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах”, 35.1.6 дахь заалтад “Барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах”, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ, 37.1.4 дэх заалтад “Барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах”, 37.1.9 дэх заалтад “Барилгын үйл ажиллагаанд холбогдох барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг баримтлан, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөлийг хангах арга хэмжээг хэрэгжүүлж холбогдох зардлыг хариуцах” гэж заажээ.

Мөн тухайн үед мөрдөгдөж байсан Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2.1-д “Захиалагчийн хяналтыг гэрээгээр гүйцэтгүүлж буй Захиалагч, захиалагчийг төлөөлж буй байгууллага нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ”, 5.2.2 дахь заалтад “Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.4-т “Захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүрэг”, 4.4.1.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилжүүлсэн эрхийн дагуу захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээг төсөл, арга хэмжээ тус бүрээр захиалагчтай байгуулах” гэж заасан байна.

Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас аймгийн Засаг даргатай 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан №01/20 дугаартай гэрээний дагуу хэрэгжүүлэн ажилласан байна.

Ингэхдээ орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсөл, захиалагчийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу ил

далд ажлын актаар баталгаажуулж, гэрээний хугацаанд гүйцэтгүүлэх талаар зөвлөмж чиглэл өгсөн байна. Мөн гүйцэтгэл нь дууссан төсөл, арга хэмжээ бүрд улсын комисс ажиллуулах Засаг даргын захирамж гарч ашиглалтад хүлээн авсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн А/12 дугаар тогтоолоор байгуулсан ажлын хэсэг 2023 оны улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим төсөл, арга хэмжээнд явцын хяналт хийж, ажлын гүйцэтгэлтэй газар дээр нь танилцаж үүрэг чиглэл өгч ажилласан байна.

Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 37.1.5 дахь заалтад “Барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах”, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт “Зураг төсөл зохиогч дараах чиг үүрэгтэй”, 38.1.3 дахь заалтад “Зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх”, 38.1.4 дэх заалтад “Зохиогчийн техникийн хяналтыг барилгын ажлын үе шатанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэх”, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 178 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 3.1-д “Зураг төсөл зохиогч барилгын ажлын захиалагчтай гэрээ байгуулан барилгын ажилд зохиогчийн хяналт тавина”, 3.3-д “Зохиогчийн хяналт гүйцэтгэх хэлбэрийг зураг төсөл зохиогч, захиалагч, барилгын ажил гүйцэтгэгч тохиролцож гэрээгээр зохицуулна”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.5-д “Зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүрэг”, 4.5.1-т “Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэгч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 4.5.1.1-т “Төсөл, арга хэмжээний зураг төсвийн зохиогч нь төслийг хэрэгжүүлэхэд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэх бөгөөд Барилгын тухай хууль, “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-д заасны дагуу “Төсөл, арга хэмжээ тус бүрээр захиалагчтай гэрээ байгуулах” гэж заасны дагуу зохиогчийн хяналтыг зураг төсөв боловсруулсан байгууллага захиалагчтай гэрээ байгуулан гүйцэтгэсэн байна.

Барилгын тухай хууль 48 дугаар зүйл “Барилга байгууламж ашиглалтад оруулах” 48.1 дэх хэсэгт “Барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулан энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулна”, Авто замын тухай хуулийн 28 дугаар зүйлд “Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах” 28.1 дэх хэсэгт “Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замыг ашиглалтад авах асуудлыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийг

ашиглалтад авах асуудлыг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан зохион байгуулна”, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 8.2-т “Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийг үндэслэн 8.1-д заасан хугацаанд багтаан дараах шийдвэрийн аль нэгийг гаргана”, 8.2.1-д “Барилга байгууламж нь ашиглалтад оруулах шаардлагыг хангасан гэж комиссын бүх гишүүд үзсэн тохиолдолд энэ дүрмийн 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс дүгнэлт гарган барилга байгууламжийг ашиглалтад оруулсан байна.

Аймгийн ИТХ-аар баталсан Хяргас нуурын эргийн тохижилт, засвар шинэчлэлийн 74.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/225 дугаар захирамжаар Хяргас нуурын эргийн тохижилт, засвар шинэчлэл 65.0 сая, Улаангом сумын 2-р багийн Хөх нуурын эргийн тохижилт 10.0 сая төгрөгийн 2 багц төсөл, арга хэмжээ болгон задалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтад “Тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх”, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 35.1.15 дахь хэсэгт “Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх Засаг даргын үйл ажиллагаанд хяналт тавих” гэж заасан байхад хяналт хэрэгжүүлээгүй байна.

Цаашид аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар баталсан тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг зөвлөмж болгов.

Б.3. Хэрэгжүүлж дууссан Хөх нуурын эргийн тохижилт 9.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг данс бүртгэлд тусгаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасан байна.

Улсын комисс хүлээн авч ашиглалтад орсон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Хөх нуурын эргийн тохижилт 9.8 сая төгрөгийг ажлыг данс бүртгэлд тусгаагүй байна.

Иймд дээрх хөрөнгийг данс бүртгэлд тусгахыг зөвлөмж болголоо.

БҮЛЭГ:В. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 1 төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаж эхлээгүй, 1 төсөл, арга хэмжээ чанар муутай хийгдсэн байна.

В.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн хог шатаах зуухыг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаж эхлээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн улсын комисс ашиглалтад хүлээн авсан Нуурын эргийн менежмент үйлчилгээг зохион байгуулах /хог хаягдал, эко жорлон/ 19.4 сая төгрөгийн төсөл арга хэмжээг Увс аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын данс бүртгэлд тусгасан хэдий ч зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй байна.

Уг хог шатаах зуухны байршлыг өөрчилж аймгийн нэгдсэн хогийн цэгт суурилуулан ажиллуулахаар ашиглалт, хамгаалалтын асуудлыг аймгийн “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-тай гэрээ хийж хүлээлгэн өгсөн боловч ажиллуулах хүний нөөц дутагдалтай гэсэн шалтгаанаар ажиллуулж эхлээгүй байна.



Цаашид хог шатаах зуухыг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар нь ажиллуулахыг зөвлөмж болгов.

В.2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Улаангом сумын 1-р Цэцэрлэгийн урлаг заалны дээврийн засвар чанар муутай хийгдсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжиж улсын комиссын ашиглалтад хүлээн авсан Улаангом сумын 1-р цэцэрлэгийн урлаг заалны дээврийн засварын 42.6 сая төгрөгийн өртөгтэй ажлыг “Саруул нутгийн зам” ХХК хийж гүйцэтгэсэн байна. Аудитын явцад зураг авалт хийхэд урлаг заалны дээврээс дусаал орж хана, таазны шохой ховхорсон байдалтай байна.



Иймд Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт “Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна”, 14.6 дахь хэсэгт “Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж,

тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна” гэж заасны дагуу дээрх зөрчлийг арилгуулахыг зөвлөмж болголоо.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний зураг төсөл, ажлын даалгавар, техникийн баримт бичгийг хууль тогтоомж, норм дүрмийн дагуу боловсруулсан байна.
2. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан нэг төсөл, арга хэмжээг Засаг даргын захирамжаар хоёр багц болгож өөрчилсөн байна.
3. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан ч 3 сум үнэлгээний хороонд төрийн бус байгууллагын төлөөлөл оруулаагүй байна.
4. Хяргас нуурын эргийн тохижилт, засвар шинэчлэлийн төсөл, арга хэмжээг үүрэг даалгавартайгаар хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон байна.
5. Гэрээний хугацаанд хийгдэж дуусаагүй 3 төсөл, арга хэмжээ байна.
6. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.
7. Хөх нуурын эргийн тохижилтын ажлыг данс бүртгэлд тусгаагүй байна.
8. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн Улаангом сумын нэгдүгээр цэцэрлэгийн урлаг заалны дээврийн засварын ажил чанар муутай хийгдсэн байна.

Холбогдох байгууллагын ирүүлсэн санал

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлд:

Аймгийн Засаг даргын ирүүлсэн 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 1/1171,

Орон нутгийн өмчийн газрын 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 133, Увс аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 150, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 259, Улаангом сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 224 дүгээр албан бичгээр тус тус тухайн тайлангийн төсөлд өгөх санал байхгүй гэсэн хариу ирүүлсэн байна.

Харин Увс аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 362 дугаар албан бичгээр “Улаангом суманд БНСУ-тай хамтран хогны иж бүрэн үйлдвэр байгуулах тогтоол гарч, ажлын хэсэг байгуулагдан ажлын даалгавар хийгдэж байгаа болон зууханд шаталтын процесс 800 градус цельсээс бага явагдах тохиолдолд аливаа хавдар үүсгэх хорт хий ялгаруулдаг тул төслийн В1-д дурдсан “...хог шатаах зуухыг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах...” зөвлөмжийг “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНӨТҮГ-т хүргүүлэх шаардлагагүй гэж үзэж байна” гэсэн хариу ирүүлсэн тул тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Зөвлөмж

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар орон нутгийн төсөв баталсан тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

Аймгийн Засаг даргад:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор баталсан төсөл, арга хэмжээг өөрчлөхгүй байх.

Аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт:

1. Гэрээний хугацаанд хийж дуусгаагүй төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч компаниар хийлгэж хүлээн авах.
2. Улаангом сумын 1-р Цэцэрлэгийн урлаг заалны дээврийн засварын ажилтай холбоотой зөрчлийг гүйцэтгэгч компаниар арилгуулах.

Байгаль орчин, аялал жуулчлалын газарт:

1. Хог шатаах зуухыг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах.

Улаангом сумын Засаг даргын тамгын газарт:

1. Хөх нуурын эргийн тохижилтын ажлыг данс бүртгэлд тусгах.

Тэс, Өндөрхангай, Зүүнхангай сумын Засаг дарга нарт:

1. Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороог байгуулахдаа хараат бус гишүүнээр иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг томилж байх.

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР
БЭЛТГЭСЭН:
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ



/М.БАТ-АМГАЛАН/

/Ч.МӨНХТОГТОХ/

/Т.ЗОЛОО/

/А.НАНЖИДМАА/